

**Монголросцветмет ТӨҮГ-ын захиалгаар хийгдэж буй төслүүд
2024 он**

№	Төслийн нэр	Төслийн товч танилцуулга	Хийгдэж буй ажлууд
1	"Бор-Өндөр" УБУ-ийн Дулааны станцыг Цахилгаан станц болгон өргөтгөх	"Бор-Өндөр" УБУ нь сард 1.3 орчим тэрбум төгрөгийн цахилгаан эрчим хүч хэрэглэдэг бөгөөд эрчим хүчний хомсдол үүсэж байгаатай холбогдуулан Эрчим хүчний хэрэглээний өсөлтийг хангах, хараат байдлыг бууруулах, Шинэ сэргэлтийн бодлогын Эрчим хүчний сэргэлтийг хангах зорилгын хүрээнд "Бор-Өндөр" УБУ-ийн дулааны станцыг цахилгаан станц болгон шинэчлэх төсөл хэрэгжүүлэхээр төлөвлөж байна.	<ul style="list-style-type: none"> - 12мВт дулааны цахилгаан станцын ТЭЗҮ батлагдсан. - Төсөл хэрэгжүүлэх газар нь "Бор-Өндөр" УБУ-ийн талбайд, дулааны станцын дэргэд байршина. - Нүүрс буулгах, хадгалах талбай шинээр байгуулах шаардлагагүй, одоо ашиглаж буй талбайг ашиглах. - Эрчим хүчний зохицуулах хороонд тусгай зөвшөөрөл хүсэх тухай өргөдөл хүргүүлсэн.
2	Хайлуурын жоншны баяжмал ФФ-97 үйлдвэрлэх үйлдвэр	Хайлуур жоншны баяжмалын ФФ-97 маркийн бүтээгдэхүүний өртөг зардлыг бууруулах зорилгоор орчин үеийн цомхон жилд 300.0-330.0 мян.тн хүдэр боловсруулан, 62.7 мян.тн ФФ-97 маркийн хайлуурын жоншны баяжмал үйлдвэрлэх үйлдвэр барьж байгуулах.	<ul style="list-style-type: none"> - Бор-Өндөр ҮТП-ийн хүрээнд "Эрдэнэс ҮТП" ХХК-тай хамтын ажиллагаа, зорилгыг уялдуулахын тулд ФФ-97 маркийн хайлуур жонш үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулахаар ажил гүйцэтгэх хамтын гэрээ байгуулан ажиллаж байна.
3	Төмрийн баяжмалыг хорголжлох үйлдвэр	"Бор-Өндөр" УБУ-ээс нойтон соронзон аргаар баяжуулсан төмрийн хүдрийн баяжмалыг хорголжлон нэмүү өртөг шингээж, экспортлох болон дотоодод байгуулагдах металлургийн үйлдвэрийг чанартай түүхий эдээр хангах, жилд 200,0 мян.тн хорголжин үйлдвэрлэх хүчин чадалтай, борлуулалтын шинэ нэр төрлийн бүтээгдэхүүн үйлдвэрлэх зорилготой.	<ul style="list-style-type: none"> - Хорголжин үйлдвэрлэх технологи туршилт, шинжилгээний ажлыг ШУТИС-ийн Механик Тээврийн Сургуулийн цутгуурын лабораторид стандарт болон чанарын шаардлага хангаж байгааг судалгааны үр дүнгээр баталгаажсан. - Үйлдвэр баригдах 27 га газрыг гэрчилгээжүүлэн авсан. - Хорголжин үйлдвэрлэх үйлдвэрийн ТЭЗҮ батлагдсан. - Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийгдэж, байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээ хийгдэж байна. - Үйлдвэр байгуулахад шаардагдах дэд бүтцийн тооцоолол хийсэн. - "Хорголжингийн үйлдвэр барих 1-р ээлж"-ийн тендер шалгаруулалт амжилтгүй болсон.
4	Нойтон баяжуулах үйлдвэр	Баргилтын төмрийн хүдрийн уурхайн төмрийн хүдрийг нойтон соронзон аргаар баяжуулан Fe-65 хувийн агуулгатай жилийн хүчин чадал нь 300 мян.тн үйлдвэрлэснээр шинээр баригдах хорголжлох үйлдвэрийг түүхий эдээр хангах.	<ul style="list-style-type: none"> - Баргилт ордын скарн-магнетитын хүдрийн баяжуулалтын судалгааг "Бигон Чойр" ХХК-ийн баяжуулах үйлдвэрт хийгдсэн. - Үйлдвэр баригдах 27 га газар. - Дэд бүтцийн тооцоолол хийсэн. - "Нойтон баяжуулах үйлдвэр"-ийн ТЭЗҮ, зураг төсвийн ажлын гэрээг "Шинжлэх ухааны паркийн захиргаа"-тай байгуулсан. Баяжуулах үйлдвэрийн ТЭЗҮ боловсруулагдан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлөөр баталгаажуулахаар хүлээгдэж байна.
5	Хайлуурын хүчил боловсруулах төсөл	Хайлуур жоншны бүтээгдэхүүний өртөг зардлыг бууруулах, бүтээгдэхүүний боловсруулалтын түвшин нэмэгдүүлж нэмүү өртөг шингэсэн, шинэлэг, зах зээлд эрэлттэй, өрсөлдөхүйц бүтээгдэхүүнийг шинэ дэвшилтэт техник технологи бүхий загвар химийн үйлдвэрлэлийг хөгжүүлэх зорилготой.	Хайлуур жоншны баяжмалаас хайлуурын хүчил гарган авах ТЭЗҮ /1-р үе шат/ - ний урьдчилсан суурь судалгаа, туршилтын гэрээг "Шинжлэх ухааны паркийн захиргаа"-тай байгуулсан. БНХАУ-ын ӨМӨЗО-ны "Өвөр Монголын Хятад Монголын технологи дамжуулах төв"-д хайлуур жоншны баяжмалаас хайлуурын хүчил үйлдвэрлэх боломжийг судлах технологийн туршилт, судалгаа хийлгэхээр хайлуур жоншны баяжмалын дээж хүргүүлж туршилтын ажил эхлүүлэх гэж байна.